

**УЛААНБААТАР ХОТЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙГ ШИНЭЧЛЭХ ХЭРЭГЦЭЭ,
ТҮҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

**Х.ЭНХЖАРГАЛ- ХСИС-ийн Гэмт явдал судлалын
магистр
Д.БУЛГАН ХСИС-ийн Цагдаа Судлалын тэнхимийн багш,
цагдаагийн ахмад**

Удиртгал. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгоход үйл ажиллагааны чиглэл, нутаг дэвсгэрийн хэмжээ, түүний төлөвлөлт, удирдлага, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, иргэдийн эрх ашгийн үүднээс сайтар бодож боловсруулан оновчтой хэлбэрээр шинэчлэх нь зүйтэй юм.

Цагдаагийн байгууллага нь орчин үеийн шаардлага хангасан тогтолцоо, бүтэцтэй болох нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал хангах, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, үндсэн зорилт, чиг үүргээ амжилттай биелүүлэх нөхцлийг бүрдүүлэх, үйл ажиллагаа тогтворжих чухал ач холбогдолтой. Мөн үүнтэй уялдуулан орчин үеийн үйл ажиллагааны арга барил буюу ард иргэдийн оролцоонд тулгуурлах чиг хандлагыг нэмэгдүүлэх нь чухал юм.

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад зөвхөн тогтолцооны шинэчлэл төдийгүй, сэтгэлгээ, зан байдалд өөрчлөлт оруулах нь зайлшгүй юм. Өөрөөр хэлбэл иргэд нийгэм, улс төрийн бүлгүүдийн дуу хоолой, санаа бодол, сэтгэл зовниж буй асуудлыг нь сонсох хэрэгтэй болно.

Цагдаагийн байгууллагын ажлын ачаалал, ажилтны гүйцэтгэх үүрэг, эрх мэдлийн зөв хуваарилалт, албад хоорондын уялдаа холбоо, зааг ялгаа, хүлээх хариуцлага ямагт тодорхой, шинжлэх ухааны үндэслэлтэй баймааж нь зохион байгуулалтын бүтэц оновчтой болно.

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг сайжруулах хэрэгцээ шаардлага нь дараахь үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно. Үүнд:

- Улаанбаатар хотын Засаг захиргааны нэгжийн хуваарилалтын онцлог
- Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагуудын харъяалах газар нутгийн хэмжээ,
- Хот төлөвлөлтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага,
- Хүн амын суурьшил, шилжилт хөдөлгөөнийг байдал,
- Гэмт хэрэг, хэв журам, захиргааны зөрчлийн өнөөгийн нөхцөл байдал зэргийг судалж боловсронгуй болгоход анхаарах нь зүйтэй байна.

Нэг. Улаанбаатар хотын Засаг захиргааны нэгжийн хуваарилалтын онцлог. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийн 3.4-д “Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн” гэж тодорхойлсон байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол Улсад нийт 1575 баг, үүний дотор хөдөөгийн 1397 баг үйл ажиллагаагаа явуулж байна. Хөдөөгийн нэг багт дунджаар 250 орчим өрх айл, хөдөлмөрийн насны 489 хүн, сургуулийн насны 274 хүүхэд, сургуулийн өмнөх насны 143 хүүхэд ажиллаж, амьдарч байна. Хөдөөгийн багийн 70.0 орчим хувь нь эрчим хүчний ямар нэгэн эх үүсвэргүй, ихэнх хувь нь холбоотой боловч тогтмол ажилладаггүй, багийн Засаг дарга нарын 22.6 хувь нь ажиллах байргүй, 35.3 хувь нь иргэддээ хүрч үйлчлэх унаагүй байна.

Багийн бүтэц, зохион байгуулалт, ажлын албыг хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, орон нутгийн онцлог зэргийг харгалзахаас гадна, хөдөөнөөс суурин газарт чиглэсэн шилжилт хөдөлгөөн, хотжих үйл явц эрчимтэй явагдаж байгаатай уялдуулан ялгавартайгаар тогтоон ажиллуулах шаардлагатай байгаа нь амьдрал дээр харагдаж байна.

Засаг захиргааны анхан шатны нэгж хороо, багийн хөгжлийг дэмжих замаар төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, чанартай болгох, хороо, багийн чадавхыг бэхжүүлэх, хороо, баг, иргэдийн хоорондын харилцааг идэвхжүүлэн тэдгээрийн эрэлт, хүсэлтийг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.

Хоёр. Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагуудын харъяалах газар нутгийн хэмжээ. Улаанбаатар хот нь нийт 4,704.4 км² нутагтай бөгөөд Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Налайх, Багануур, Багахангай гэсэн 9 дүүрэгт хуваагддаг. Дүүрэг бүр нь хороодод хуваагдана. Мөн Налайх, Багануур, Багахангай гэсэн 3 дүүрэг, хотын төвөөс алслагдсан байдаг¹.

Улаанбаатар хотын дүүргүүдийн газар нутгийн хэмжээ нь нийтдээ 4,704.4 км², үүнээс чингэлтэй дүүрэг 89.3, Хан-Уул 484.7, Сүхбаатар 208.4, Сонгинохайрхан 1,200.6, Налайх 687.6, Баянзүрх 1,244.1, Баянгол 29.5, Багахангай 140.0, Багануур 620.2 км квадрат газар нутагтай байна.

Улаанбаатар хот Монгол Улсын нийт газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг. Нийслэлийн нэг км квадрат газарт 236.6 хүн оршин суудаг. Газар нутгийн хэмжээг дүүргээр нь ангилбал нийслэлийн газар нутгийн ихэнхийг Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг эзэлдэг ажээ.

Хүн амын нягтшилыг дүүргээр нь авч үзвэл Баянгол дүүрэгт нэг км квадрат газар нутагт 5928 хүн ногддог. Харин Багахангай дүүрэгт нэг км квадрат газар нутагт 25.7 хүн ногддог байна.

Энэ нь Улаанбаатар хот Монгол Улсын нийт нутаг дэвсгэртэй ахьцуулахад бага газар нутагт хамаарах ч хүн амын сууршлийн төв бүс гэдгээр анхаарал хандуулах нь зүйтэй юм.

Гурав. Хот төлөвлөлтийн байдал. Хот төлөвлөлтийн асуудал нь Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгоход заавал анхаарч үзэх асуудал юм. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг Монгол Улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан².

Улаанбаатар хот нь нэг төвт хот юм. Улаанбаатарыг бага, их тойргоор төлөвлөн байгуулж, төрийн эрх барих дээд байгууллага, яамд, гадаадын элчин сайдын яамд, санхүү бизнес, худалдаа үйлчилгээ, соёл шинжлэх ухааны болон боловсролын байгууллагууд зэрэг олон улс, нийслэлийн чанартай, төр захиргааны бүхий л байгууллага их, бага тойрогт байрлаж, үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Нийслэл хот жил ирэх тусам өргөжин тэлж, энэхүү өсөлт хөгжлийг даган бий болж буй хэрэгцээ шаардлагыг нэг төвт хот хангаж чадахгүй болсон тул Улаанбаатар хотыг олон төвт, орчин үеийн хот болгон хөгжүүлэх зорилтыг энэхүү Ерөнхий төлөвлөгөөгөөр дэвшүүлсэн. Ингэснээр Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийг төлөвлөлтийн найман бүс болгон хөгжүүлнэ. Төлөвлөлтийн эдгээр найман бүс нь тус бүрдээ засаг захиргаа, худалдаа, үйлчилгээ, нийгмийн дэд бүтцийн үйлчилгээ бүхий иж бүрэн цогцолбор төвтэй байх юм. Эдгээр бүсийг орон сууц, олон нийтийн бүс, үйлдвэрлэл, сайжруулсан гэр хорооллын зэрэг дагнасан болон хосолмол чиг

¹ <https://mn.wikipedia.org/wiki/Улаанбаатар>

² Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага.
http://mpa.ub.gov.mn/images/NET/ub_2030_et/II_boti.pdf

үүрэгтэй төлөвлөлтийн 47 нэгж хороолол болгон хөгжүүлнэ. Олон нийтийн бүсийг хотын чанартай төв, дүүрэг-бүсийн төв, хорооллын төв, анхан шатны төв гэсэн 4 шатлалтайгаар төлөвлөв.

1. Хотын чанартай төв: Хотын хуучин төв, Яармагт байгуулах шинэ төв орно. Эдгээр төвүүдэд улс, олон улсын чанартай, төр захиргаа, шинжлэх ухаан, боловсрол соёл, олон нийтийн төв байгууллага, үйлчилгээ, бизнесийн байгууллага төвлөрч Улаанбаатар хотын бизнесийн төв дүүргийн үүрэг гүйцэтгэнэ.
2. Дүүрэг-бүсийн төв: Нисэхийн шинэ хот, Сонсголон, Гурвалжин, Баянхошуу, Сэлбэ, Амгалан зургаан дэд төвийг шинээр байгуулна. Хот, дүүргийн ач холбогдол бүхий төрийн захиргаа, худалдаа үйлчилгээ, орон сууц, олон нийтийн барилга байгууламж төвлөрнө.
3. Хорооллын төв: Хороолол бүр хүн амынхаа хэрэгцээнд нийцсэн олон нийтийн төвтэй байна. Энд хороо захиргаа, олон нийт, үзвэр, худалдаа үйлчилгээ, банк санхүүгийн байгууллага, эмнэлэг, сургууль зэрэг байгууллага үйл ажиллагаа явуулна.
4. Олон нийтийн анхан шатны бичил төв: Оршин суугчдын өдөр тутмын хэрэгцээг хангахад чиглэсэн худалдаа, нийтийн аж ахуй болон нийгмийн үйлчилгээ төвлөрсөн бичил хороолол, хотхонд үйлчлэх зориулалттай анхан шатны олон нийтийн төвүүдийг хүн амын суурьшлыг дагалдуулан, алхаж хүрэхэд ойр, хүртээмжтэй байхаар төлөвлөв.

Хот төлөвлөлтийн ерөнхий чиг хандлагаас харахад Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын бүтэц нь зайлшгүй өөрчлөгдөхөөр харагдаж байна.

Дөрөв. Хүн амын суурьшил, шилжилт хөдөлгөөнийг байдал. Сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт нэмэгдэж, хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тоо тогтвортой байгаагаас шалтгаалан нийслэл хотын хүн амын өсөлтөнд ердийн өсөлтийн эзлэх хувийн жин жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод 2015 оны 1-р сарын 1-ний байдлаар 627837 эрэгтэй, 686649 эмэгтэй буюу нийт 1314486 хүн байнга оршин сууж байна.

Нийслэл Улаанбаатар хотын суурин хүн амын тоо 2013 оноос 47.5 мянган хүнээр буюу 3.7 хувиар өсчээ. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг тооллого явагдсан онуудаар авч үзвэл: 1956-1963 онд хамгийн өндөр буюу 9.5 хувь, 1963-1969 онд 3.0 хувь, 1969-1979 онд 4.2 хувь, 1979-1989 онд 3.1 хувь, 1989-2000 онд 3.0 хувь, 2000-2010 оны хооронд 3.9 хувь, 2010-2014 оны хооронд 3.3 хувиар тус тус өсчээ.

2000 онд шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент буюу 1000 хүн ам тутамд ногдох механик өсөлт 25 байсан нь ердийн хөдөлгөөний цэвэр коэффициент буюу 1000 хүн ам тутамд ногдох ердийн цэвэр өсөлтөөс бараг 3 дахин их байсан бол 2014 оны байдлаар 1000 хүн ам тутамд ногдох цэвэр өсөлтийн түвшин механик өсөлтийн түвшнөөс 1.4 дахин илүү болсон байна.


Нийслэл хотод 2014 онд 31356 хүн албан ёсоор шилжин ирж, 30.2 хувь буюу 9470 нь Сонгинохайрхан, 22.5 хувь буюу 7060 нь Баянзүрх, 13.9 хувь буюу 4362 нь Баянгол, 11.5 хувь буюу 3618 нь Чингэлтэй, 9.1 хувь буюу 2851 нь Хан-Уул, 8.4 хувь буюу 2627 нь Сүхбаатар, үлдсэн 4.4 хувь буюу 1368 нь Багануур, Багахангай, Налайх дүүрэгт тус тус суурьшжээ³.

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-аас хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөнийг найман бүс, 47 нэгжид жигд суурьшуулан төвлөрлийг сааруулах чиг хандлагатай байхаар үзэл баримтлалыг бий болгосон.

³ <http://ubregion.ub.gov.mn/>

Гурав. Улаанбаатар хотын 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал⁴.

Нийт 324367 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас:



Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

-Нийслэлийн хэмжээнд 17939 гэмт хэрэг бүртгэгдсэн.

-өмнөх оны мөн үетэй харьцуулахад 734 хэргээр буюу 4.3 хувиар өссөн.

Шалгасан захиргааны зөрчил:

\Нийт 1151800 /давхардсан тоогоор/ захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 775486 буюу 3.1 дахин өсчээ.

-Зөрчил гаргасан 1120347иргэн, 16 албан тушаалтан, 981аж ахуйн нэгж, байгууллагад 14.0 тэрбум төгрөгөөр торгох,

-17106 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах,

-1 хүнийг тээврийн хэрэгсэл хасаж, баривчилах

-6928 хүнийг торгож, эрх хасах,

-6420 хүнд баривчлах,

- 1 хүнийг торгож, баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

-Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 97560 хүн саатуулагдсанаас 59042 буюу 60.5 хувь нь Улаанбаатарт, 38518 буюу 39.5 хувь нь орон нутагт, тэдний 5442 буюу 5.6 хувь нь эмэгтэй, 387 буюу 0.4 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байх ба 339 хүнийг архины албадан, 503 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан байна.

Гэмт хэргийг нутаг дэвсгэрээр нь харьцуулан үзвэл нийслэлд нийт гэмт хэргийн 64.7 хувийг эзлэх бөгөөд 4.3 хувийн өсөлттэй байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2014	2015		2014	2015
Орон нутагт	10093	9779	-3.1	36.9	35.2

⁴ Монгол Улсад 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. Цагдаагийн ерөнхий газар. Мэдээлэл, технологийн төв.

Нийслэлд	17205	17939	4.3	63.0	64.7
Бусад газарт	20	39	95.0	0.1	0.1

Харин захиргааны зөрчлийг нутаг дэвсгэрээр нь авч үзвэл 271288буюу 19.1 хувь нь орон нутагт, 1151800 буюу 80.9 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шилжилт хөдөлгөөн, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөл, гарсан хэрэг, зөрчлийн тоог харгалзан үзэхэд Засгийн Газрын дагуу “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 153 дугаар тогтоолын дагуу эдийн засгийн зохистой зардлыг тооцсон бүтэц, орон тоо, автомашин, тусгай хэрэгслийн хангалт, тэдгээрийн эдэлгээ, гүйлтийн жишиг нормативын хүрээнд Нийслэлийн оршин суугаа 100 мянган хүнд ноогдох цагдаагийн ажилтны тоог 280-300 байхаар тооцож үзвэл 5600 – 6000 алба хаагч байна гэж үзвэл 2449-2900 алба хаагчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Ингэж бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийснээр зөвхөн Нийслэлийн Цагдаагийн газар, Нийслэлийн Замын цагдаагийн газраас нийт 150 офицер, 70 ахлагч нийт 250 алба хаагчийн орон тоо нутаг дэвсгэрийн цагдаагийн нэгжид шилжиж, иргэдэд шууд үйлчилгээ үзүүлэн ажиллах боломжтой болох юм.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны бүтэц болон эрх мэдлийн харилцаа хамаарлыг тодорхойлдог процессыг зохион байгуулалт хийх гэдэг. Зохион байгуулалт хийхдээ дараахь зүйлсэд анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд:

1. Ямар ажил хийх ёстойг тодорхойлох,
2. Ажил үүргийг хэрхэн бүлэглэхийг тодорхойлох
3. Албан тушаалын дэс дараалал тогтоох
4. Ажил үүргийн хариуцлага болон эрх мэдлийг тэнцвэржүүлэх гэх мэт зүйлсийг анхаарч зохион байгуулалтын бүтцийг хийх нь хэрэгтэй.

Мөн цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц нь гурваас дээшгүй шатлалтай байх нь зүйтэй.

Нэгдүгээрт: тэргүүн эгнээнд ажиллаж буй цагдаагийн анхан шатны нэгж

Хоёрдугаарт: мэргэшсэн, дэмжлэх үзүүлэх хэлтэсүүдтэй дүүргийн менежмент

Гуравдугаарт: байгууллагын менежмент ба төвийн газар хэлтсүүд байна.

Эдгээрээс Улаанбаатар хотын, дүүргийн цагдаагийн хэлтсүүд гол байр суурийг эзлэх бөгөөд аль болох өөрөө өөрийгөө дэмжих чадвартай байвал зохино.

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын бүтэц нь дүүрэг болгонд адилхан байх албагүй бөгөөд дүүргийн хэмжээ, хийж гүйцэтгэх ажлын цар хүрээ, болон дэд бүтэц зэрэг гадны хүчин зүйлсээс хамааралтай байдаг. Гэхдээ гүйцэтгэх ажил үүрэг, функцийг цар хүрээндээ тохирсон байх ёстой тул нэг их том ялгаа байдаггүй.

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн гол томъёолол бол төвлөрөлийг сааруулах юм. Өөрөөр хэлбэл байгууллагын бүтэц, албан тушаал болгоны гүйцэтгэх үүрэг роль болон хариуцах ажлын хүрээг дахин хянан үзэхдээ эрх мэдэл, хариуцлага, санхүүгийн төлөвлөлтийг анхаарч үзэх нь зүйтэй. Энэ нь

- Төвлөрлийг сааруулсан түвшин төвөөсөө дүүргийн хэмжээнд
- Дүүргүүд дэх төвлөрлийг сааруулсан байдал
- Дүүргүүдийн тоо зэргийг харгалзана.

Дүгнэлт. Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэх шаардлагатай бөгөөд энэ нь дээрх үзүүлэлтүүдээс харагдаж байна. Үүнийг хэрэгжүүлэхдээ төвлөрлийг сааруулж олон төвт, 8 бүсд тохирсон, 4 шатлалд тохирсон зохион байгуулалтыг бий болгох нь ард иргэдтэй харилцаа холбоогоо сайжруулах, цагдаагийн байгууллагын үр бүтээлтэй үйл ажиллагааг сайжруулахад чухал нөлөө үзүүлнэ. Төвлөрлийг сааруулахын тулд өргөн цар хүрээтэй, холыг харсан алхамыг хийх хэрэгтэй байна.

Дараахь саналыг дэвшүүлж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4-д “Монгол Улсын Засгийн Газар оршин суугаа хүн амын тоог харгалзан нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг хотын цагдаагийн хэлбэрээр байгуулж болно” гэснийг үндэслэн Монгол Улсын Засгийн газар 2014 оны 4 сарын 4-ний өдрийн 115 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Цагдаагийн газрыг байгуулсан. Нийслэлийн хүн амын суурьшил нэмэгдэж байгаа болон эрүү, хэв журмын нөхцөл байдлыг харгалзан, мөн Нийслэлийн Засаг Даргын 2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрүүдэд дэвшүүлсэн зорилттой уялдуулан хотын цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, тогтолцоо бүтцийг өөрчлөхдөө дараахь нөхцөл байдлыг харгалзан үзлээ.Үүнд:

1. (А хувилбар) Замын цагдаагийн албаны жолооч бэлтгэх, үнэмлэх олгох, орон нутгийн замын хөдөлгөөний хяналтын чиг үүргүүд нь ЦЕГ-ын бусад алба, нэгжүүдэд шилжиж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлууд нь ЦЕГ-ын Нийтийн хэв журмыг хамгаалах газрын чиг үүрэгт шилжсэн боловч одоогийн Нийслэлийн Цагдаагийн газрын бүтцэд байгаа Нийтийн хэв журам хамгаалах газар, Замын цагдаагийн газар гэдэг давхар бүтцийг нийтийн хэв журам хамгаалах албаны үйл ажиллагаа жигдрэх хүртэл тодорхой бус хугацаанд хэвээр нь үлдээж, замын хөдөлгөөн зохицуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий Нийслэлийн Замын цагдаагийн газрыг зарчмын ялгаагүй хэлтэс, алба нэгжүүдийг нь нэгтгэн, цомхон бүтэцтэй байхаар санал боловсруулав. Бүтцийн схем зургийг хавсралтаар оруулав⁵.

2. (Б хувилбар) Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал хамгаалах үндсэн чиг үүрэг бүхий газар, хэлтэс, тасаг, хэсэг, дэд хэсэг гэсэн бүтэцтэй байхаар заасан.

Хууль Зүйн Сайдын А/12 тушаалаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлуудыг ЦЕГ-ын Нийтийн хэв журмыг хамгаалах газрын чиг үүрэгт багтааж шийдвэрлэсэн тул одоогийн Нийслэлийн Цагдаагийн газрын бүтцэд байгаа Нийтийн хэв журам хамгаалах газар, Замын цагдаагийн газар гэдэг давхар бүтцийг нэгтгэн Нийслэлийн Нийтийн хэв журам хамгаалах газрын харьяанд нэгдсэн бодлоготой уялдуулан үйл ажиллагаагаа явуулах чиг үүрэг бүхий Нийслэлийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хэлтэс байхаар төлөвлөв. Хавсралтаар схем зургийг оруулав⁶.

3. (В хувилбар) Цагдаагийн ерөнхий газрыг Үндэсний цагдаагийн газар, Улаанбаатар хотод Цагдаагийн ерөнхий газар, дүүрэгт Цагдаагийн газар, дүүргүүд нь нутаг дэвсгэр, хүн амын нягтрал зэргээс хамаарч 1, 2, 3 дугаа хэлтэстэй байх бөгөөд хэлтсийг дүүргийн цагдаагийн газар нь нэгтгэн удирдах, хэлтсийн дор 1-3 хороо хариуцсан тасагтай байхаар төлөвлөж санал боловсрууллаа⁷. Энэхүү зохион байгуулалтын бүтцээр иргэд, олон нийт тодорхой асуудлаа шийдвэрлэхэд хүндрэл учруулахгүй, шатлал дамжихгүйгээр чиг үүргийнхээ дагуу үйл ажиллагаагаа явуулна. Өөрөөр хэлбэл газар, хэлтэс, тасаг, хороо өөрийн хариуцсан ажлын хүрээнд бие даан шийдвэр гаргах эрхтэй байхаар зохион байгуулагдана.

⁵ Хавсралт 1-оос харна уу?

⁶ Хавсралт 2-аас харна уу?

⁷ Хавсралт 3-өөс харна уу?


4. НЦГ-ын НХЖХГ-ын бүтцэд байгаа Урьдчилан сэргийлэх хэлтэс, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, НЗЦГ-ын бүтцэд байгаа Урьдчилан сэргийлэх хэлтэс гэсэн нэг ижил чиг үүрэг бүхий гурван хэлтсийг нэгтгэн нэг хэлтэс байхаар зохион байгуулсан нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нэг чигт төвлөрөн нэгдсэн бодлого зохицуулалттайгаар үр дүнтэй явагдах боломжтой болно гэж үзэж байна.
5. НЗЦГ-ын бүтцэд байгаа Хөдөлгөөний хяналтын хэлтэс, Хөдөлгөөн зохицуулах гэрээт хэлтэс гэсэн чиг үүргийн ялгаа багатай давхардсан хэлтсийг татан буулгаж, нутаг дэвсгэрийн цагдаагийн нэгжид байгаа Замын цагдаагийн алба хаагчид чиг үүргийг нь гүйцэтгэж байхаар санал болгов.
6. Цагдаагийн дэд хэсгийн бүтцийг дараахь байдлаар санал болгож байна. Засаг захиргааны үндсэн нэгж болох хороо тус бүрт одоо ажиллаж байгаа хэсгийн байцаагч, хорооны гэсэн тодотголтой боловч хороон дээр байршин ажилладаггүй хороо хариуцсан төлөөлөгч, мөрдөн байцаагч гэсэн 3-4 хүний бүрэлдхүүнтэй анхан шатны нэгжийг Цагдаагийн албаны тухай Монгол улсын хууль, Монгол улсын Засгийн газраас 2014 оны 3 сард баталсан Цагдаагийн байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Сингапур, Япон зэрэг гадаад орнуудын цагдаагийн байгууллагын туршлага, Цагдаагийн албаны хуулийн хүрээнд хийсэн судалгааны дүгнэлт зэрэгт тулгуурлан цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээг анхан шатны нэгжээс шуурхай, хүртээмжтэй, чирэгдэлгүй үзүүлэх шинэ орон зай бий болгох зорилгоор 17-30 алба хаагчийн бүрэлдхүүнтэйгээр хороо тус бүрт **ЦАГДААГИЙН ДЭД ХЭСГИЙГ** байгуулан ажиллуулахаар дараах саналыг боловсруулав. Дэд хэсгийг хотын хэмжээнд жигд тараан байршуулсанаар алслагдсан болон хотын захын хороодод цагдаагийн бүх төрлийн үйлчилгээг иргэд ойр зайнаас, тодорхой хариуцсан албан тушаалтнуудтай тулж харьцан авах боломж буй болохоос гадна цагдаа, олон нийтийн хамтын ажиллагаа ойртох таатай нөхцөл бүрдэнэ.

Хороодын засаг дарга өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа иргэдийн ая тухыг алдагдуулж, хэв журам зөрчиж байгаа бүхий л асуудлыг цагдаагийн байгууллагатайгаа хамтран шийдвэрлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хууль сахиулах ажиллагаанд иргэд, цагдаагийн байгууллага иргэд дунд орж хамтран ажиллах бололцоогоор хангагдана.


Хүн амын суурьшил, хөдөлгөөний нягтрал ихтэй байгаа дэд хэсгийн орон тоог нэмэгдүүлэн 24 цагаар тасралтгүй ажиллуулсанаар шөнийн цагаар нэг дүүрэгт гэмт хэргийн дуудлагад очих бүрэлдхүүний тоо 2 байсан нь 8-10 болж нэмэгдэх бөгөөд нэгж хугацаанд туулах зай, цаг хугацаа хэмнэгдэж, иргэдэд учруулах чирэгдэл багасах зэрэг олон давуу байдал бий болно.

Уншиж танилцсан: Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор
Ж.Долгорсүрэн

Хавсралт 1



Хавсралт 2



Хавсралт 3

